

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 11 дүгээр сарын 21-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7-33
<hr/>	
<i>1. Байнгын хорооны даргыг сонгох тухай</i>	7-8
<i>2. “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан Боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Төсвийн байнгын хорооноос санаачлан боловсруулсан, эцсийн хэлэлцүүлэг/</i>	8-8
<i>3. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	9-14
<i>4. Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.31-ний өдөр Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/</i>	14-33

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 11 дүгээр сарын 21-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 45 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: С.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Л.Мөнхбаатар, Ч.Хүрэлбаатар;
Томилолттой: Ж.Батжаргал, С.Одонтуяа, Б.Чойжилсүрэн.

Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнг Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн талаарх саналыг Улсын Их Хурал дахь Монгол ардын намын дарга Д.Тогтохсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасны дагуу санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэнг Төсвийн байнгын хорооны даргаар сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан Боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Төсвийн байнгын хорооноос санаачлан боловсруулсан, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал

хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гаргах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд С.Чинзориг хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.31-ний өдөр Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан, Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Бямбадулам, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Хуулийн хэлтсийн дарга Ж.Ичинноров, мөн албаны Газар чөлөөлөх хэлтсийн дарга Н.Мөнхбаяр, Нийслэлийн орон сууцны бодлогын газрын дарга Г.Ганхүү, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хот байгуулалт хөгжлийн газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Д.Хан-Уул, “Нийслэлийн орон сууцны корпорац” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Говьсайхан, “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” УТҮГ-ын захирал Ч.Батзориг, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр, төслийн зохицуулагч Д.Авирмэд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

1.Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

2.Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

3.Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 6
Бүгд: 10
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

5.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ш.Раднаасэд нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан, Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

6.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

7.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

8.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн тавьсан асуултад Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн хариулж, тайлбар хийв.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

9.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

10. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Төрийн байгууллатын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 44 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 29 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим, 13 цаг 45 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Та бүхэнд хуралдааны ирцийг танилцуулъя. Амартүвшин гишүүн хүрэлцэн ирсэн байна. Тогтохсүрэн гишүүн, Баделхан гишүүн, Даваасүрэн гишүүн, Хүрэлбаатар гишүүн, Батжаргал гишүүн, Раднаасэд гишүүн, Мөнхбаатар гишүүн, Сандаг-Очир гишүүн нар өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд хүрэлцэн ирсэн байна. Ингээд Байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудлаар 4 асуудал байгаа. Бусад асуудлын хүрээнд 1 дүгээр асуудал нь Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал байна.

Хоёрдугаарх нь, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан Боловсрол, Эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл Төсвийн байнгын хороо санаачилсан эцсийн хэлэлцүүлэг байгаа.

Гурав дугаарх нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл анхны хэлэлцүүлэг байгаа.

Дөрөв дүгээр нь Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд

өөрчлөлт оруулах тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газраас өргөн баригдсан хуулийн төсөл байгаа. Анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлэх гэсэн ийм 4 асуудал байна.

Хэлэлцэх асуудлын төсөлтэй холбогдуулаад саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

1 дүгээр асуудал. Төсвийн байнгын хорооны даргалд нэр дэвшигчийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн даргад танилцуулна. Тогтохсүрэн даргын даргын микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Байнгын хорооны гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын тухай хуулиар Төсвийн байнгын хорооны даргын бүрэн эрхийн хугацаа 1 жил байна. 1 жилийн хугацаагаар улиран сонгогдож болно гэсэн ийм хуультай. Энэ хуулийн дагуу Тэмүүлэн дарга 2022 оны 8 сард Байнгын хорооны дарга болсон. Бүрэн эрхийн хугацаа дууссан учраас үргэлжлүүлэн ажиллуулах ийм саналыг Монгол Ардын намын бүлгээс оруулж байгаа юм. Өөрөөр хэлбэл Төсвийн байнгын хорооны

дарга Ганзоригийн Тэмүүлэнг Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байгаа.

Тэмүүлэн даргын намтар түүхийг нь бол бүгдээрээ мэднэ. Архангай аймгийн уугуул, 2003 онд Америкийн Олон улсын харилцааны сургуулийг бакалавраар төгссөн. 2005 онд Олон улсын удирдлагын магистраар хамгаалсан. Ажилласан байдал бол 2006 онд Ашигт малтмал газрын тосны газрын хэлтэст мэргэжилтэн, 2007 оноос Ашигт малтмал газрын тосны газрын гэрээлэлтийн хэлтэст ахлах мэргэжилтэн, 2008-2009 онд Ашигт малтмал газрын тосны газрын хэлтсийн дарга, 2009-2014 онд төрийн өмчит Эрдэнэс MGL компанийн дэд захирал, 2013-2015 онд Оюутолгой компанийн ТУЗ-ийн гишүүн, 2014-2015 онд Уул уурхайн дэд сайд, 2015 оноос Нийгмийн ард Ардчилал Монголын Залуучуудын холбооны ерөнхийлөгч, 2016 оноос өнөөдрийг хүртэл Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байгаа. 2022 оноос Төсвийн байнгын хорооны даргаар ажиллаж байгаа ийм гишүүн байгаа.

Тэгээд Тэмүүлэн гишүүнийг Улсын Их Хурал дахь олонхын бүлэг буюу Монгол Ардын намын бүлгээс Төсвийн байнгын хорооны даргад нэрийг нь дэвшүүлж байна. Байнгын хорооны гишүүд та бүгдийг дэмжиж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Тогтохсүрэн даргад баярлалаа. Монгол Ардын намын бүлгээс гаргасан танилцуулгатай холбогдуулж асуулттай гишүүд байна уу. Алга байна. Танилцуулгатай холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Төсвийн байнгын хорооны даргаар нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Санал хураалтын дүнг танилцуулъя. Санал хураалт 70 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд танилцуулах юм байна. Баделхан дарга танилцуулах уу. Баярлалаа танд. Баделхан даргаар танилцуулъя. Ингээд энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

13.50 цаг.

2 дахь асуудалдаа оръё.

“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан Боловсрол, Эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Эцсийн хэлэлцүүлэг байгаа.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг тогтоолын төсөлд нэмж тусгаад эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн байгаа. Тэгээд та бүхэнд бэлтгэсэн төслийг тараасан байгаа. Эцсийн хувилбартай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна гэж ойлголоо. Батжаргал гишүүн бас эцсийн хэлэлцүүлэг дээр зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлдсэн юм байна. Тэгэхдээ гарын үсэг зураагүй учраас өөрөө бас байхгүй байна. Ингээд эцсийн хувилбарын төсөвтэй холбогдуулж санал гаргах гишүүд байхгүй байна. Эцсийн хувилбарын төсөвтэй холбогдуулж асуулт асуух гишүүд алга байна. Ингээд тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн талаарх Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир гишүүн та танилцуулах уу. Сандаг-Очир гишүүн танилцуулъя. Тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

13.52 цаг.

3 дахь асуудалдаа оръё. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Байнгын хороонд оруулаарай. Нийгмийн бодлогын байнгын хороо Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцээд, санал, дүгнэлтээ ирүүлсэн байна. Санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир гишүүн танилцуулах юм байна. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар хийж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороодод ишлэжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаараа Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлэх үед төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир зайлиггүй шаардлагаар гадаадад улсад эмчлүүлэх өвчний жагсаалтыг хэн баталдаг, тэдгээр өвчнийг дотооддоо эмчлэхэд

хүний нөөц болон техник, технологийн асуудлыг шийдвэрлэх шийдвэрлэхэд ямар бодлого баримталж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүд Д.Сарангэрэл зайлиггүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний зардлыг нэмэгдүүлэхээр хуулийн төсөлд тусгасныг дэмжиж байгаа бөгөөд цаашид зардлыг бүрэн хариуцах боломжийн талаар, эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдийг сургах, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд хэрхэн анхаарч ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа хуулийн төсөл нь Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний анхдагч хуулийн төсөлтэй хэрхэн нийцэж байгаа эсэх, Нас барсны дараа заавал задлан хийлгүйгээр гэр бүлийнх нь хүсэлтийг харгалзан орчин үеийн дэвшилтэт технологи ашиглаж MRI болон XRay аппаратаар шинжлэх техник тоног төхөөрөмжийн төсвийг тусгах боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут Эрүүл мэндийг дэмжих сангаас өнгөрсөн хугацаанд хэдэн иргэн хэдэн төгрөгийн санхүүжилт авсан талаар, цаашид дотооддоо эмчлэх боломжгүй өвчнийг эмчилдэг болоход ямар ч зохицуулалт, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Төсвийн байнгын хорооны эрхэм гишүүд ээ

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүнд баярлалаа. Нийгмийн бодлогын

байнгын хорооны санал, дүгнэлтийг сонслоо.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Пүрэвийн Оюунцэцэг, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Дангаагийн Баярболд гэсэн бүрэлдэхүүн байна.

Хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэх учиртай байгаа. Ингээд тухайн зүйлтэй холбогдуулж хууль санаачлагчаас болоод бусад оролцогчоос асуулт асууж болно гэж заасан байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дуудаарай. Сандаг-Очир гишүүн, Даваасүрэн гишүүн Сандаг-Очир гишүүнээр тасалъя. Даваасүрэн гишүүний микрофоныг өгье.

Ц.Даваасүрэн: Чухал санал гэж би бодож байна. Яагаад гэвэл хүний амь настай холбогдолтой асуудал. Ялангуяа ядуурал хүн амын 30 хувь шахуу болчихсон байгаа энэ үед олон хүмүүс мөнгөний асуудлаас болоод гадаадад эмчлэх шаардлагатай өвчнийг эмчилж чадахгүй эндэж байгаа. Тэгэхээр даатгал гэдэг ер нь бол ийм л эрсдэлийг санхүүжүүлэхэд чиглэсэн байдаг учраас бид нар ер нь энэ даатгалын тогтолцоогоо цаашаа боловсронгуй болгож, өндөр төлбөртэй өвчнүүдийг ялангуяа Монголд эмчлэх боломжгүй эмчлүүлж байгаа өвчнүүдийг хамруулдаг болох чиглэлээр бид нар нэлээн дорвитой санхүүг нь бүрдүүлэх чиглэлд анхаарах ёстой. Тэгэхээр миний асуух гээд байгаа юм ер нь энэ сангаа яаж бүрдүүлж явах юм, яаж арвижуулах юм гэдэг талаас нь ер нь ямар бодлого байна вэ гэж. Мэдээж хэрэг гадаадад эмчлэх шаардлагатай өвчний талаар өөрсдөө сурах талд бас анхаарах ёстой. Гаднын мэргэжилтнүүд авч асруулах, эндээ

боловсон хүчнээ бэлдэх, тоног төхөөрөмжөөрөө хангах энэ тэр гээд асуудал шийдэх ёстой. Тэр болтол хугацаанд бид нар даатгалын сангаараа дамжуулаад тодорхой хэмжээгээр бол иргэддээ дэмжлэг үзүүлдэг байх шаардлагатай. Хүний алтан амь шүү дээ. Бид нар бол энийг л хэзээ ч, хэнд ч тохиолдож болно гэж ингэж бодож хандахгүй бол өөрт тохиолдоогүй болохоороо бид нар чинь хайхрахгүй яваад байгаа байхгүй юу. Яах вэ л гээд. Тэгэхээр хэзээ нэг цагт хэнд ч тохиолддог эд гэдэг агуулгаар нь иймэрхүү арга хэмжээнүүдийг дэмжих хэрэгтэй.

Мөнгө санхүүгийн асуудлаа шийдэж чадахгүйгээс тэр гэр бүлд маш том хагацал учирч байгаа шүү дээ. Тэрийг л бид нар мэдэрч ойлгож л ухамсарлаж, энэ чиглэлийн арга хэмжээнүүдийн эх үүсвэрийн хувьд бас боломжтой байхаар ингэж шийдэж өгөх нь дээр байх. Тэгээд очер дараалал үүсээд л эсвэл арын хаалгадаад л гэдэг юм уу, нөгөө янз бүрийн шан харамж авч байж хүн ордог ч гэдэг юм уу иймэрхүү яриа гаргахгүй байхын тулд бас бололцооны эх үүсвэр бүрдүүлэх чиглэлд ер нь бол анхаарах ийм шаардлагатай гэж ингэж бодож байна. Тэгээд ер нь цаашидаа эх үүсвэр талаас нь яаж бүрдүүлж явах юм бэ гэдэг талаас нь би тодотгоодохъя. Энэ бол маш чухал эд.

Г.Тэмүүлэн: Даваасүрэн гишүүнд баярлалаа. Даваасүрэн гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг 3 номер. Албан тушаал, өөрийгөө танилцуулаарай. Сайдыхаа дуудаарай. 3 номер ажлын хэсэг. Чинзориг сайд асуултад хариулъя. Чинзориг сайдын микрофоныг өгье.

С.Чинзориг: Тусгай сангийн тухай хуулиар Эрүүл мэндийг дэмжих сан гэж одоо ажиллаж байгаа. Энэ эрүүл мэндийг дэмжих сангийн орлогын эх үүсвэр нь 3 орлогоос эх үүсвэр бүрдэж байгаа юм. Архи, тамхины онцгой

татварын 1-2 хувь, эмийн гааль, НӨАТ-ын татварын 2 хувиас эх үүсвэр бүрдэж байгаа юм. Энэ яг хувиар нь тооцоод үзэхэд жилд 10-12 тэрбум төгрөг Эрүүл мэндийг дэмжих санд төвлөрөхөөр тооцоо байгаа. Яах вэ сүүлийн жилүүдэд төсөв батлахдаа Эрүүл мэндийг дэмжих сан дээр яг гүйцэтгэлээр нь тооцож эх үүсвэр тусгаж өгөхгүй 2-3 тэрбум төгрөгийг л Эрүүл мэндийг дэмжих санд төсөвт тусгаж санхүүжүүлэх арга хэмжээ авдаг. 2023 онд бол Эрүүл мэндийн сайдын багцад Эрүүл мэндийг дэмжих санд нь 2 тэрбум төгрөг тусгасан. Ер нь Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр зөвхөн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд буюу иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэлт тэгээд тандалт судалгаа нөлөөллийн ажил хийхэд зарцуулж байгаа. Би бол энэ дэмжих сангийн хамрах хүрээг нь жаахан өргөжүүлж өгөөд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зарцуулах буюу ялангуяа дотооддоо оношилж эмчилж чадахгүй байгаа өвчнийг оношилдог, эмчилдэг шинэ технологи нэвтрүүлэх зардлыг нь энэ сангаас олгодог болъё гэсэн хуулийн төсөл бол өргөн бариад байгаа юм.

2024 оны улсын төсөв дээр Сангийн сайдтай ярьж байгаад Эрүүл мэндийг дэмжих санд 2023 оныхоосоо 5 дахин хөрөнгийг нэмэгдүүлээд 10 тэрбум төгрөг 2024 оны төсөвт бол тусгаж батлагдсан. Тэгээд энэ хөрөнгөөр бид нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, тэгээд нийт хөрөнгийнхөө 50-60 хувийг нь шинэ технологи нэвтрүүлэх, нутагшуулах зардалд олгодог болгоё гээд байгаа. Одоогийн практикаар бол шинэ технологи нэвтрүүлэх зардлыг тухайн эрүүл мэндийн байгууллага өөрөө хариуцаж хийе гэхлээр шинэ технологи нэвтрүүлэх асуудал бол нэлээд удааширалтай яваад байгаа юм. Миний бодож байгаа хуульд өөрчлөлт ороод батлагдах юм шинэ технологи нэвтрүүлэх зардлыг Эрүүл мэндийг

дэмжих сангаас нь санхүүжүүлдэг болгоё. Тэгээд энэ технологи нэвтрэлээ гээд тэр мэргэжлийн салбар зөвлөл нь дүгнэлт гаргавал цааши нь нөгөө Эрүүл мэндийн даатгалын сангаасаа санхүүжилт аваад явдаг байх ийм боломжийг нь олгож өгье гэсэн ийм хуулийн төсөл байгаа. Ингээд дэмжих сангийн журмыг нь Засгийн газар батална. Засгийн газарт журам оруулахдаа шинэ технологи нэвтрүүлэх гэдгийг нь ямар асуудал ямар үйл ажиллагааг хэлэх вэ, зөвхөн шинээр Монгол Улсад технологи шинээр нэвтрүүлэх технологийг хэлэх үү эсвэл төрөлжсөн томоохон эмнэлгүүд дээр Монголдоо нутагшуулсан технологи байсан ч гэсэн орон нутгуудад бас технологи нэвтрүүлэх ажлыг нь дэмжих үү гэдэг асуудлууд яригдана.

2 дугаарт үндэсний багийг бас гадаад улс орнуудад сургаж чадавхжуулах, гадаад улс орнууд бас өндөр туршилагатай, чадавхтай баг урьж ажиллуулж туршилагыг нь үндэсний багт бас сургаж авах гэсэн ийм бас ажиллагаа хийе гэсэн ийм чиглэлээр Тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн бариад байгаа юм.

Г.Тэмүүлэн: Даваасүрэн сайд нэмж тодруулъя.

Ц.Даваасүрэн: Тэгвэл энэ жил төсвөөс 10 тэрбумыг нэмээд явах гэж байгаа юм байна шүү дээ. Тэгээд 20 тэрбум. 200 саяар бол 100-аад хүн юм уу тээ. Бас болж л байна л даа. Тэгэхээр хэдүүлээ энэ 10 тэрбум гэдэг чинь бараг 1 байшингийн мөнгө л болчихоод байна шүү дээ. Тэгээд 1 хүний амь гэдэг байшингаас хямдхан байна гэж юу байх вэ. Тэгээд тэр олон байшин сургууль энэ тэр объектоосоо 1, 2-ыг ч болтугай нь хүний эмчилгээнд зарцуулаад явах нь зөв байх. Тэгээд цаашидаа эх үүсвэрээ нэмэх чиглэл дээр бас анхаараад явахгүй бол орлого багатай иргэдийн хувьд ёстой нээрээ үнэхээр хаашаа ч яаж ч чадахгүй

тэгээд л алдаж байгаа шүү. Ойр дотнынхоо улсуудыг хүнд өвчнүүдээр. Тийм учраас бид нар бол хэдэн 100 тэрбумыг төсөвтөө хөрөнгө оруулалтад.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Чинзориг сайд нэмж тайлбар өгөх үү.

С.Чинзориг: Яах вэ, 2024 оны төсөв батлагдчихсан. Тэгээд энэ хууль батлагдвал 2024 оны 1 сарын 1-ээс хэрэгжүүлье гэж байгаа юм. Тэгээд 2024 оны тухайд батлагдсан 10 тэрбум төгрөгтэй бол үйл ажиллагаагаа явуулаад явъя.

2 дугаарт хуульд орж байгаа нэг өөрчлөлт бол сая Даваасүрэн гишүүн яриад байх шиг байна. Ер нь дотоодод оношилж, эмчилж чадахгүй байгаа өвчний улмаас гадагшийгаа зайлшгүй шаардлагын улмаас эмчилгээнд явж байгаа иргэдэд яваад ирсэн хойно эмчилгээнийх нь зардлын 5 хувийг нь өгч байгаа юм. Энэ бол маш бага байна гэж. Тийм учраас бид журмынхаа төсөл дээр засаг руу оруулъя гэж бодож байгаа. Хүүхдийн эмчилгээний зардлыг 50 хувийг нь, насанд хүрэгчдийн эмчилгээний зардлыг нь 20 хувийг нь өгдөг болгоё гэсэн ийм л юм. Одоо гэхдээ яах вэ, чамлахаас чанга атга гэж одоо бол 5 хувиа өгч байгаа шүү дээ. Тэгээд ядаж энийг нь үе шаттайн эмэгдүүлье л гэж л байгаа юм.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Сандаг-Очир гишүүн асуулт асууя. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Би сая Нийгмийн бодлогын байнгын хороо дээр бас асуусан. 5 хувиа одоо өгч байгаа. Тэгэхээр сая та ярьж байна. Ер нь цаашидаа зүгээр хүүхэд бол 50 хувийг нь, том хүн бол 20 хувийг нь өгдөг байя гэдэг чинь зүгээр таны бодол уу ийм шийдвэр гарч байгаа юм уу эсвэл ийм журам орж ирэх гэж байгаа юм уу гэдгийг нэгд тодруулж асууя.

2-т энэ төрөөс өгч байгаа тодорхой хувь нь Чинзориг сайд аа, явахынхаа өмнө өгөх юм уу, явж ирснийхээ дараа баримтаа бүрдүүлээд яамнаас гэдэг юм уу, холбогдох газраасаа тэр хувиа авах юм уу. Энийг хүмүүс бас их асуугаад байгаа юм. Нөгөө талаар энийг хэлэлцэх эсэх дээр чуулган дээр би Ганхуяг гишүүнтэй санал нэг байгаа юм. Ганхуяг гишүүний хэлж байсан саналтай. Тусгай сангуудын асуудал ямар асуудлууд үүслээ тэгээд энийг та нэг ажлын хэсэг томилдог, тэгээд нөгөө ажлын хэсэг дээр ажлын хэсгийн үйл ажиллагаа, сонгон шалгаруулах дээр чинь л яг энэ ажлын хэсгийн үйл ажиллагааг ил тод нээлттэй болгохгүй бол тэгээд тэр ажлын хэсэгт орсон Эрүүл мэндийн яамныхан л өөрсдийнхөө ах дүү, хамаатан саднуудыг юу гэдэг юм тэр талаа явуулах, явуулахгүйн баталгаа нь юу байгаа юм. Ийм байдлаар ингээд тусгай сангуудын үйл ажиллагааг дунд шатдаа завааруулдаг ийм байгаа шүү. Тийм учраас тийм байдал гаргахгүйн тулд таны журмаар сайдын тушаалаар батлагдах тэр журмыг хэрхэн яаж иргэд олон нийтэд ил тод, нээлттэй байлгах юм. Хэн явсан юм, хэн яваагүй юм, хэдэн төгрөг авсан юм гэдгийг яаж цаашидаа ер нь ил тод нээлттэй болгох юм. Олон нийтийн хяналтад яаж байлгах юм гэдэг юмыг энийг нэг та нэг хэлж өгөөч ээ гэдгийг тодруулж асууя.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Чинзориг сайд.

С.Чинзориг: Зайлшгүй шаардлагаар гадагшаа эмчилгээнд яваад ирсэн иргэдийн зардлынх нь 5 хувийг л өгч байгаа юм. Нэгэнт өөрөө төр өөрөө дотооддоо оношилж эмчилж чадахгүй байна гэж хэлж байгаа атлаа энэ өвчнөөр гадагшаа эмчилгээнд яваад ирсэн иргэддээ санхүүгийнх нь 5 хувийг өгдөг дэндүү бага байна гэж үзээд тэгээд үе шаттай нэмэгдүүлье л гэж байгаа юм. Миний хэлээд байгаа тэр

хүүхдийн эмчилгээний зардлаар 50 хувийг, насанд хүрэгчдийн эмчилгээний зардлын 20 хувийг өгье гэдэг бол манай яамны хийж байгаа тооцоо, миний байр суурь. Ийм санал Засгийн газар руу оруулна. Тэгээд дэмжих эсэх нь Засгийн газар шийдэх байх. Би бол ийм тооцоотой, тоотой Засгийн газар руу оруулъя гэж байгаа. Тэр журмыг нь сайдын тушаалаар батлахгүй журмыг нь хуулиар нь Засгийн газрын тогтоолоор батлах юм. Засгийн газар батлах юм. Үе шаттай нэмэгдүүлье. Тэгээд ирэх жил 2024 онд 50, 20 болгоё гэсэн ийм бодолтой байна. Тэгээд цаашдаа 2025, 2026 он гээд нэмэгдээд явах болов уу гэсэн ийм бодолтой байна.

Би Сандаг-Очир гишүүнтэй санал бол нэг байна. Ер нь иргэдийн дунд тусгай сангуудад итгэх итгэл бол нэлээн алдарсан. Тийм учраас бусад сангууд шиг болгочих вий дээ. Мэдээлэлд ойр албан тушаалтай хэсэгхэн улсуудад үйлчилдэг ийм сан болгочих вий дээ гэдэг ийм болгоомжлол байна. Би ч гэсэн ийм болгоомжлол байна. Ийм зүйлд бас оруулчихгүйн төлөө журмыг нь боловсруулж оруулна гэдгээ би чуулган дээр байр сууриа илэрхийлж байсан. Хамгийн гол нь иргэдийн оролцоотой, хяналттай байлгах тэр бүхий л боломжийг нь хангаж ажиллана гэсэн ийм бодолтой байна. Гэхдээ энэ журмыг нэлээн сайн гаргахгүй бол нийтдээ гадагшаа эмчилгээнд яваад байвал төлбөр өгөх юм шиг бас ийм хэт өрөөсгөл ойлголт яваад, асар их хүлээлт бий болчих вий гэдэг би бас болгоомжлол байна. Нөгөө талдаа би бол гадагшаа явж байгаа иргэдэд эмчилгээнд нь зардал өгөхөөс илүүтэйгээр дотоодод оношилж эмчилж чадахгүй байгаа өвчний төрлийг эмчилдэг байх оношилдог байх. Тэр шинэ технологи нэвтрүүлэх ажлыг нь илүүтэй бас дэмжье. Ингэж чадах юм бол иргэдийн гадагшаа эмчлүүлэхээр оноилуулахаар бас явдаг урсгал багасах юм. Ингэж байж иргэд маань гадаад улс оронд өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээнд хамрагдах, өндөр

өртөгтэй эмчилгээнд хамрагдаж санхүүгийн эрсдэлд дарамтад орохгүй байх энэ нөхцөл боломжийг нь бүрдүүлэх нь илүү оновчтой юм гэж үзэж, энэ сангийн хөрөнгийн нэг дийлэнхийг нь тэр технологи нэвтрүүлэх зардалд нь бас зарцуулдаг байх нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаа. Миний бодож байгаагаар бол технологи нэвтрүүлсэн гэдэг асуудлыг бол 2024 онд яг дотооддоо ийм өвчнийг эмчилдэг байх шинэ технологи нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага байна гэдгээ яам зарладаг, тэгээд тэрнийхээ дагуу төсөл сонгон шалгаруулж тэр оношилгоонд, эмчилгээнд нь технологи нэвтрүүлэх шаардлагатай байгаа зардлыг нь энэ сангаас бас олгодог байх нь зүйтэй гэж бодож байгаа.

Ер нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлэхтэй холбоотойгоор хөрөнгө оруулалт шаардлагатай бол бий. Ялангуяа тоног төхөөрөмжтэй холбоотойгоор. Гэхдээ бүхий л шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийг зөвхөн тусгай сангийн хөрөнгөөр шийднэ гэж бол ойлгож болохгүй ээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд эрүүл мэндийн салбарт шаардлагатай байгаа оношилгоо шинжилгээний эмчилгээний тоног төхөөрөмжийг бас хүртээмжийг нь нэмэгдүүлэх ийм бас бодлого баримталж явах нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай бол байна.

Г.Тэмүүлэн: Чинзориг сайдад баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байн.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй учраас хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргаж болно гэж заасан байгаа. Тэгээд эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг бас та бүхэнд гаргаж байна. Горимын саналаар санал хураалтыг явуулъя. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд санал хураалтад анхааралтай оролцоорой. Санал хураалт 72,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир нэгдсэн хуралдаанд танилцуулна. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

14.13 цаг.

4 дэх асуудалдаа орцгооё. Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн

албан татвараас чөлөөлөх тухай, Хувь хүний албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай Засгийн газар 2023 оны 10 сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд байгаа. Төсвийн байнгын хороо санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлэх ийм дэгтэй асуудал юм байна.

Нийслэл хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын сайд Дэлгэрсайхан танилцуулна. Дэлгэрсайхан сайдын микрофоныг өгье.

Б.Дэлгэрсайхан: Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн нэгдүгээр бүлэг буюу нийтлэг үндэслэл гэдэг энэ өмнө нь орж ирсэн хуулийн концепци дээр бол зарчмын хэд хэдэн өөрчлөлтүүд оруулж ирж байгаа юм.

Тухайлбал, энэ хуулийн зорилт нь бол иргэний саадгүй зорчих нөхцөлийг нэмэгдүүлэх, нийтийн тээврийн төсөл хүртээмж, авто зогсоолын ашиглалтыг сайжруулах, хотын төвлөрлийг сааруулах, сайжруулах, мөн гэр хорооллыг орон сууцжуулах, түгжрэл, орчны бохирдлоос үүсэх нийгэм, эдийн засгийн нөлөөллийг бууруулахад оршино гээд энэ өмнөх хуулийн зорилт гэдэг 1.1-ээ ингэж томъёолсон байгаа. Тэгээд дээрээс нь өмнө нь өргөн барьсан хууль дотроосоо зарчмын зөрүүтэй 2, 3 санал хураалгах гэсэн юм. 7 дугаар зүй дээр байгаа замын хөдөлгөөний төлбөртэй бүсийн төлбөр ногдуулах, төлөх гэдэг 7 дугаар заалтыг бүхэлд нь энэ хуулиас авах, дээрээс нь 7 дугаар зүйл замын хөдөлгөөний төлбөртэй бүсийн төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх гэдгийг

бүхэлд нь 8.2.1, 8.2.2 бүхэлд нь авах ийм гэсэн ийм 3 томъёоллоор санал хураалгах гэж байгаа юм.

Ингэдэг нь ямар учиртай юм бэ гэхээр, түрүүн өргөн барьсан хууль дээр... дагасан хууль ярьж байгаа юм уу. Уучлаарай.

Г.Тэмүүлэн: Дэлгэрсайхан сайдын танилцуулга ирсэн байх. Дэлгэрсайхан сайд хуулийн төслийн талаарх танилцуулгыг танилцуулна.

Б.Дэлгэрсайхан: Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн талаар.

Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу нийслэл хот өөрийн нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг нийгмийн асуудлыг бие даан шийдвэрлэх эрхтэй болсон. Нийслэл хотод тулгамдаад байгаа төвлөрөл, төлөвлөлт дагасан олон асуудлын үр дагавар нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг ноцтой хөндөж байгаа тул хүний суурь, жам ёсны эрхийг хамгаалах, нийгмийн дэг журам, нийтийн ашиг сонирхлыг хангахын тулд зарим эрхийг тохирсон хэмжээнд хуулиар хязгаарлах зайлиггүй нөхцөл байдалд хүрээд байна.

Хотын хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, тохижилт, түүнийг дагасан тээврийн хэрэгслийн тооноос шалтгаалан Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл сүүлийн жилүүдэд

үлэмж нэмэгдсэнээр тээврийн хэрэгслийн дундаж хурд 9км-ээс цаг болсон. Сүүлийн 3 жилийн байдлаар жилд дунджаар 47 мянган тээврийн хэрэгсэл нийслэл Улаанбаатар хотод бүртгэгдэж байна. Энэ үргэлжилбэл 2030 онд 5км цаг, 2040 онд 0км цаг байх тооцоолол гарч байна.

Улаанбаатар хотын авто замын сүлжээний урт сүүлийн 10 жилийн хугацаанд 531км-ээс 1213км болж 43%-аар нэмэгдсэн боловч энэ хугацаанд 667,8 мянгаас 712 мянга хүртлээ 93%-аар нэмэгдсэн. Нийслэл хотод бүртгэлтэй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг авто замыг нэвтрүүлэх чадвар хангаж чадахгүй байна.

Судалгаагаар 2021 онд Улаанбаатар хотод түгжрэлээс үүдсэн нийгэм, эдийн засаг, байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн улмаас алдагдсан боломжийн өртөг 3,8 их наяд төгрөгт хүрч, энэ нь Монгол Улсын ДНБ-ий 9%-тай тэнцэж, нийслэл хотын хүн амын тоонд харьцуулан үзвэл нэг хүнд ноогдох өртөг 2 сая 478 мянган төгрөг болж байна. Улаанбаатар хотын 1 иргэн жилд дунджаар 30 хоног буюу 717 цагийг түгжрэлд алдаж байна.

Улс орнууд түгжрэлтэй бүс тогтоох, шатахууны борлуулалт, татвар ноогдуулах, төлбөртэй зам барих зэргээр замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах олон шийдлийг хэрэгжүүлж байгаагаас түгжрэлтэй бүсийг тогтоох нь замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулахад өндөр нөлөө үзүүлнэ гэж үзэж байна. Нийслэл хотын замын хөдөлгөөний нөхцөл байдал нь хот төлөвлөлтийн гажуудал, авто замын сүлжээ, даац хэтрэлт, иргэдийн зорчилт, хөдөлгөөн судлаачдын зөвлөмж зэрэг хүчин зүйлийг тооцон үзэж, нийслэл хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулахад тээврийн хэрэгсэл, эрэлтийн менежмент, ялангуяа түгжрэлтэй бүсийн тогтолцоог бий болгох нь зүйтэй гэж үзлээ.

Улаанбаатар хотод замын хөдөлгөөний төлбөртэй бүс, түүний хилийн зааг, цагийн хязгаарлалтыг тогтоож, төлбөртэй бүсэд тогтоох, төлбөртэй бүсэд нэвтрэх тоогоороо 0-оос хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хүртэлх хувьтай тэнцэх мөнгөн дүнтэй байхаар тогтоож, төлбөрийн хэмжээг энэ хязгаарт багтаан нийслэлийн иргэдийн... минут дуусав.

Г.Тэмүүлэн: Дэлгэрсайхан сайдын микрофоныг нэмж өгье.

Б.Дэлгэрсайхан: Нийслэлийн төлөөлөгчдийн хурлаар тогтоохоор хуулийн төсөлд тусгалаа. Төлбөртэй бүсийн төлбөрөөс тус бүсэд оршин суугч иргэний тээврийн хэрэгслийг 90%-аар, зөвшөөрөлтэй такси үйлчилгээ 50%-аар хөнгөлнө. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулагдсан тээврийн хэрэгсэл, байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүрэн хараагүй, бүрэн хэлгүй, бүрэн дүлий одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүн тээвэрлэх зориулалтаар зөвшөөрөл авсан, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн тээврийн хэрэгслийг төлбөртэй бүсийн төлбөрөөс чөлөөлөхөөр тусгалаа.

Түгжрэлийн төлбөрийн орлогоор нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, явган алхах, дугуй унах хэвшлийг түгээн дэлгэрүүлж, замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулаад зогсохгүй хүн амын эрүүл мэндийг хамгаалахад зарцуулах бөгөөд нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж, төвлөрсөн багтаамж ихтэй авто зогсоолын асуудлыг шийдсэний дараа төлбөртэй бүсийг тогтоож төлбөр ноогдуулах зохицуулалтыг хэрэгжүүлж эхлэхээр тусгалаа.

Сүүлийн үед нийгэм такси үйлчилгээтэй холбоотой олон хэрэг

зөрчил гарах боллоо. Ялангуяа цагдаагийн байгууллагын гэмт хэргийн мэдээллийн санд сүүлийн 5 жилд бүртгэгдсэн такси үйлчилгээтэй холбоотой нийт 3119 гэмт хэрэг бүртгэгдсэнээс нийслэлд дийлэнх нь буюу 2940 гэмт хэрэг бүртгэлтэй байна. Үүнээс 2636 гэмт хэрэгт таксинь жолооч холбогдож, гэмт хэрэг үйлдэж байгааг онцгой анхаарч цэгцлэх зайлшгүй шаардлагатай байна. Такси үйлчилгээг хуульд заасан нөхцөл аюулгүй байдлын шаардлага хангасан этгээд тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх, түүнд тавих хяналт зохицуулалтыг бий болгохыг зорилоо.

Мөн авто тээврийн хэрэгслийн хэрэглээг татварын бодлогоор хязгаарлах хэд хэдэн хуульд өөрчлөлт оруулахаар тусгалаа. Улаанбаатар хотод бүртгэлтэй суудлын автомашины татварын дээд хэмжээг 2 дахин нэмэгдүүлэхээс гадна уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцэх мөн олон улсын гэрээ, конвенцын дагуу Монгол Улс нь нүүрсхүчлийн хийн хэрэглээг хязгаарлах бодлогын хүрээнд нүүрсхүчлийн хийн хэрэглээнд шууд ноогдуулдаг татвар болон агаарын бохирдлын төлбөрийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлэхээр тусгав.

Замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, хүн амын төвлөрлийг сааруулах, орчны бохирдол асуудлыг шийдвэрлэх оновчтой шийдэл нь гэр хорооллын инженерийн дэд бүтцээр хангах, дахин төлөвлөж барилгажуулах явдал юм. Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд 2021 оны байдлаар 412,5 мянган өрх амьдарч байгаагаас 51,4% буюу 212 мянган өрх нь орон сууцад, үлдсэн 48,6% буюу 200 мянган өрх гэр хороололд амьдарч байна.

Нийслэлд хүн амын тал хувь нь гэр хороололд буюу инженерийн дэд бүтцийн хангамжгүй, агаар, хөрсний бохирдолтой нөхцөлд амьдарч байна. Хуулийн төсөлд нийслэл хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд

тусгагдсан дэд төвүүдийн байриил, гэр хорооллыг орон сууцжуулах нийгмийн зайлиггүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх үндэслэлийг нарийвчлан тодорхойлж, газар чөлөөлөлтийн нөхөн олговрын газрыг газраар дүйцүүлэн олгох, газрыг үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгөөр, газрыг нөхөн олговрыг мөнгөн зардлаар худалдан авах буюу бусад боломжит хэлбэрээр олгож байхаар тусгалаа.

Хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд заасны дагуу Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслүүдийг эрчимжүүлж орон сууцжуулах төслийг хэрэгжүүлсний үр дүнд дараах нийгэм, эдийн засаг, байгаль орчны нөлөөллийн үр дагавар гарна гэж үзэж байна.

Улаанбаатар хотын агаар, хөрс, орчны бохирдлын голомт болж байгаа гэр хорооллын бүс болох Сэлбэ, Баянхошуунд соёл, спорт, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий дэд төвийг орон сууцжуулах төслийг тэргүүн ээлжид эхлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

Ингэснээр хүн амын орлогод нийцсэн ногоон хөгжлийн загварт тохирсон орон сууц нийлүүлэлтийг хувийн хэвилийн оролцоотойгоор нэмэгдүүлж 19500 орон сууц шинээр баригдаж 68250 хүн ая тухтай амьдрах нөхцөл орчин бүрдэнэ. Зайлиггүй орон байраар хангагдах шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийг түр орон сууцаар хангадаг тогтолцоог нэвтрүүлнэ. Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдэд суурилсан 25295 ажлын байр шинээр бий болж ДНБ 2,5 их наяд төгрөгөөр нэмэгдэнэ. Сэлбэ, Баянхошуу дэд төвүүд бий болсноор агаарын бохирдол 20 хувиар, авто замын түгжрэл 36,3 хувиар бууруулахаар урьдчилсан тооцоолотой байна. Нийслэл Улаанбаатар хотын замын

хөдөлгөөний түгжрэл төлөвлөлтийн алдаанд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг цогцоор нь шийдвэрлэх зорилгоор нийт 25 хуулийн төсөлд холбогдох өөрчлөлт оруулахаар багцаар боловсрууллаа.

Тухайлбал ЗХАБТХ-д иргэн, хуулийн этгээдийг торгох шийтгэл, замын хөдөлгөөний төлбөртэй бүс болон авто зам, замын байгууламж ашигласны төлбөр, авто замын болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг хугацаанд нь төлөөгүй, техникийн хяналтын үзлэг, оношилгоонд ороогүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахыг хориглохоор тусгалаа.

Цаашид өсөн нэмэгдэж буй тээврийн хэрэгслийн тоог хэвийн хэмжээнд байлгахын тулд Авто тээврийн тухай хуульд нийслэлд олгох тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тооны дээд хязгаарыг Нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн НИТХ-аар батлуулахаар тусгаж, тус хязгаарт багтаан тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг олгохоор зохицууллаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Дэлгэрсайхан сайдад баярлалаа. Ингээд энд хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя.

Борхүүгийн Дэлгэрсайхан сайд, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга, Пүрэвжавын Сайнзориг Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан 1 дүгээр орлогч, Дорждэрэмийн Цолмон Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх, Жалбажавын Бямбадулам Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Жаргалсайханы Ичинноров Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Хуулийн хэлтсийн

дарга, Насанбатын Мөнхбаяр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Газар чөлөөлөх хэлтсийн дарга, Ганбатын Ганхүү Нийслэлийн орон сууцын бодлогын газрын дарга, Ганболдын Батзориг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Чимэддоржийн Батзориг Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж төрийн өмчит үйлчилгээний газрын захирал гэж байгаа юм. Доржготовын Хан-Уул Хот байгуулалт, хөгжлийн газрын БХБ-ын хэлтсийн дарга, Тунгаагийн Авирмэд Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн зохицуулагч, Маньбазарын Говьсайхан Нийслэлийн орон сууцын корпорац ХК-ийн гүйцэтгэх захирал. Ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэйгээр оролцож байгаа юм байна.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх байгаа. Зүйл бүрээр та бүхэн бас хууль санаачлагчаас болоод бусад оролцогчоос асуулт асууж болохоор байгаа. Ингээд хуулийн төслүүдийг хэлэлцэж эхэлье.

1.Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. 3 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүн байна уу. Раднаасэд гишүүнээр тасалъя. Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Ажлын хэсэг дээр чухам яаж ирсэн юм. Энэ зүгээр миний л санаа шүү. Одоо энэ татварыг хуулиар бий болгож, өөрчилж, хүчингүй болгоно гээд нэг өгүүлбэр байгаа. Татварын ерөнхий хууль дээр байгаа. Хуульд өөрөөр заагаагүй бол гэдэг агуулгаар бичээд эс

үгүй бол нийслэл өөрсдөө татвараа тогтоодог хэлбэр лүү оруулах хэрэгтэй. Нийслэлийн иргэдийн Хурал яг ямар асуудал шийдэж байна вэ. Төсөв батлахаас өөрөөр. Одоо өнөөдөр нохой муурын асуудал бид нар Их Хурал дээр яриад л явж байна. Энэ яг Их Хурлын ажил мөн ч юм уу бас. Нийтийн тээвэр, такси, тэгээд өөр юу байна. Тэр хог цэвэрлэгээ, зүлэгжүүлэлт энэ бүх юмнуудыг ямар л юм байна шийдэж болох юмнуудыг нь нийслэлд нь өөрт нь өгөөд, иргэдийн хурал өөр дээр асуудал шийддэг баймаар байгаа байхгүй юу. Хог шороо, автобус, нийтийн тээврийн үйлчилгээ, авто зогсоол, такси, таксины үйлчилгээ зөвшөөрөл гээд л энд яриад байгаа юм. Тэгээд хандлага чинь өөрсдөө үбэр гээд дэлхий өөрөө тэр таксинаас чинь бараг гараад явж байхад араас нь бид нар дахиад таксины зөвшөөрөл гээд л юм яриад л. Тэгэхээр энэ уян хатан байдлыг нь хангах үүднээс би нийслэл рүү бол тодорхой юмнуудыг нь өгч байх ёстой юм болов уу гэж бодоод байгаа юм. Яг орж ирсэн хэмжээнд нь бид засах биш бүр зарим эрхийг нь тэр чигт нь нийслэлд өгөөд нийслэл өөрөө тэртээ тэргүй бас л сонгогдсон алба. Нийслэлийн иргэдийн Хурлын Төлөөлөгч гэдэг бас л тодорхой хүмүүсийн санал авч гарч ирсэн хүмүүс байгаа юм. Энэ жагсаалтыг нь гаргаж байгаад ийм ийм асуудлуудыг нийслэл шийднэ. Ерөнхий том хязгаарын юмыг нь бол Их Хурал дээр ингэж шийднэ гэдгийг хийгээд татвартай холбоотой, хураамжтай холбоотой, зохицуулалттай холбоотой тэгээд бид нар өнөөдөр хэдэн машины зохицуулалт яриад дахиад түгжрэлийг шийдэж чадахгүй л дээ. Дахиад л нөгөө сургуулийн хүүхдийн асуудал байна. Автобус нийтийн тээврийн асуудал гарч ирнэ ингээд энэ бүгд чинь эд нар богино хугацаанд юмаа шийддэг байхын тулд байсхийгээд л хуулиа Их Хурал руу барьж орж ирдэг болно.

2 дахь юм энэ түгжрэлийн хуультай холбоотой бид нар дагасан хууль ярьж байна. Төрийн байгуулалтын

байнгын хороо дээр байгаа гишүүд очиж бас ярина биз. Нийслэлд их давхацсан бүтцүүд байдаг юм байна. Одоо энэ Нийслэлийн байгаль орчны газар гэж юу хийдэг юм бүү мэд. Хөдөлмөр халамж үйлчилгээ гэж юу хийдэг юм. Дүүргүүдэд нь байгаа. Нийслэлийн онцгой байдал гэж яадаг юм. Дүүргүүдэд нь бас байгаа. Эрүүл мэндийн газар гээд юу хийдгийг нь мэдэхгүй. Энэ бүтцээ нийслэл өөрсдөө шийддэг байх. Хэрэгцээтэй газраа хүмүүсээ ажиллуулаад, тэгээд хэрэггүй бүтцээ цомхотгож янзалж, цэгцэлдэг. Бүтэц батлах эрхийг нь тэр нэгжийн хууль дээр харин засвар хийж байгаад Нийслэлд нь өгчихмөөр байгаа байхгүй юу. Тэгэхгүй нэгбүрчилсэн байдлаар батална нийслэлийг гээд. Аймгуудыг бол нийтлэг байдлаар батална ч гэдэг юм уу нэг ганц үгэнд ороогдоод Засгийн газраас баталж өгсөн хэмжээнд явдаг. Энэ нэг дамжуурга шинжтэй ийм албуудыг нь нийслэлд нь өөрт нь өгөөд, орон тооны хязгаар юм хумаа жоохон эрх чөлөөг нь өгөөд энэ хүмүүсийг ажиллуулаад иц үзэх ёстой юм шиг байгаа юм. Тэгэхгүй бол одоо удахгүй Их Хурал дээр бид нар байшингийн лифтний асуудал ярина шүү. Одоо нохой муур яриад л сууж байгаа. Энэ чинь бол хотын л асуудал байхгүй юу. Тэр Говь-Алтай аймаг, тэр Сэлэнгэ аймаг, Дорноговь аймагт тэр гэрийн тэжээвэр нохой, муур асуудал биш байгаа шүү дээ. Зөвхөн өнөөдөр байгаа Улаанбаатарт л зовлон болчихсон гэх мэтчилнээр ийм юмнуудыг нь бид нар томоор нь энийг яаж авч хоорондоо ер нь ярьсан юм уу. Дахиад л авто тээврийн, өөрөө явагч хэрэгслийн албан татвар, дагаад Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар тэгээд газрынх ингээд л юм явна. Бүгдийг нь хөдөлгөнө л дөө. Тэгж байтал энэ чинь буруу байна гээд л дараа жил нь дахиад л өөрчлөх гээд энийгээ оруулж ирнэ.

Агаарын бохирдлын төлбөрийг нийслэл өөрөө тогтоодог байх хэрэгтэй шүү дээ.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг хариулах уу. Ажлын хэсэг 4 номер. Албан тушаал, овог нэрээ танилцуулаарай.

Д.Цолмон: Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Цолмон байна. Ерөнхийдөө орон нутгийн татварын асуудлыг хууль, тогтоомжоороо орон нутагт нь шилжүүлэх асуудал та асууж байх шиг байна. Тэгэхээр Авто тээврийн болон өөрийн авагч хэрэгслийн албан татварын тухай хуульд ерөнхийд нь суудлын автомашины албан татварыг бүсчилсэн байдлаар тогтоочихсон байдаг. 5 дугаар зүйлийн 1 дээр нь Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг, Орхон аймаг гээд ерөнхийдөө бүсчлээд тухайн бүсчлэлд байгаа автомашины суудлыг багтаамжаар нь ангилж, тухайн албан татварыг бол ногдуулдаг. Тэгэхлээр энэ дээр бид хэд Улаанбаатар хотыг салгаад, албан татварын хэмжээг бол дээд хэмжээг нь 2 дахин өсгөсөн ийм хуулийн төслийг боловсруулсан байгаа. Ерөнхийдөө Үндсэн хууль дээр бол аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бол хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд л тухайн татварын хэмжээг тогтоох эрхтэй байдаг. Тэгэхээр энэ хууль дээр орон нутагт нь өөрт нь эрхийг нь өгөөд, тухайн татварын интервалаар дээд, доод хэмжээг нь тавьж өгсөн тохиолдолд орон нутаг өөрөө татварынхаа хэмжээг тогтоогоод явах боломжтой. Гэхдээ энэ хуульд маань ерөөсөө тийм эрх олгосон нөхцөл байхгүй, хатуу тогтоочихсон татвартай учраас бид хэд Улаанбаатар хотын мөрдөгдөх татварын хэмжээг салгаж, дээд хэмжээг нь нэмэгдүүлж төсөлд тусгасан байгаа.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Моторын багтаамжаар л бид хэд татвар тогтоох

гээд л оролдоод байна л даа. Тэгэхээр Улаанбаатар хотод яг нарийн даа хязгаарлалт хийх ёстой багтаамжийн маань доод интервал нь хэд юм. Тэрийгээ бодож тэрнээс дээших дээрээ тавьдаг төлбөрөө нэлээн өндөрсгөж л тавимаар байгаа юм. Тэгж байж л үр дүн нь гарна. Тэгээд одоо та хэдийн оруулж ирчхээд байгаа санаа бол ерөөсөө бүх шатлал дээр нь интервал тавиад, тэгээд тэр 2 интервалын хооронд нээх учиргүй хүнд мэдрэгдээд байхаар зөрүү харагдахгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр зэрэг ер нь бид ямар байдлаар энэ асуудалдаа хандах юм л гэдэг ийм л зүйл байгаад байгаа юм л даа. Энэ талаасаа хармаар юм шиг. Тэгээд том судалгаа дээр тулгуурлаад ороод ирж байгаа учраас зөв байлгүй дээ. Хүнд цаг үед улсуудын дургүйг нэмж хүргэв дээ. Ийм л юм харагдаад байх юм мэдэхгүй.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг номер 4.

Д.Цолмон: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Суудлын автомашины багтаамжийн ангилал бол 3 ангилалтай байгаа. 2001, 2001-3001, 3001-ээс болон түүнээс дээш гээд. Тэгээд яг энэ ангиллын дагуу албан татварын хэмжээ интервал нь дээд, доод хэмжээ тогтоогдсон. Тэгээд энэ дээр бол бид хэд багтаамжаас нь шалтгаалсан татварын хэмжээг нэмээгүй. Харин цахилгаан тэжээлт автомашин дээр бол татвар авдаггүй байсныг бид 2001сантиметр куб цилинтертэй автомашинтай адилтгаж албан татвар нэмж авах ийм зохицуулалтыг бол тусгасан байгаа. Нэмээд хэлэхэд энэ интервалын хооронд бол тухайн орон нутаг өөрөө иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь багтааж татварын хэмжээг тогтоох ийм хуулийн зохицуулалттай байгаа.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн нэмж тодруулъя.

Ж.Батжаргал: Үгүй ээ, үгүй. Тэрийг бол би ойлгоод л байна л даа. 3001-ээс дээш моторын багтаамжтай тээврийн хэрэгсэл дээр 22-132 л гэж байгаа байхгүй юу. Нэг юундаа ноогдох юу нь. Тэгэхээр зэрэг 2001-3001 нь 18-108, 3001-ээс дээших нь 22-132 гэсэн ийм л интервал өгчхөөд байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь бараг ялгагдахгүй шахуу л юм байна шүү дээ. Тэгээд үнэхээрийн тэр моторын багтаамж өндөртэй, ялгаруулах хий өндөртэй, тэгээд овор хэмжээ томтой ийм тэрэгнүүд дээрээ ер нь хязгаарлалт юмаа хийнэ л гэж бодож байгаа бол бас нэг жоохон ялгаж харагдахаар л юм байвал уг нь бид нарын зорилго хангагдах болов уу л гэж бодоод байх юм.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг хариулъя. Сангийн яам 6 номер.

Б.Тэлмүүн: Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн. Батжаргал гишүүний асуултад хариулъя. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар бол цэвэр орон нутгийн төсөвт ордог. Орон нутаг өөрөө бодлогоо гаргаж, орон нутаг хувь хэмжээгээ тогтоодог ийм онцлогтой татвар. Энэ өргөн мэдүүлсэн хуулийн төсөл дээр бол бид үндсэн авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварынхаа үндсэн харилцааг бол хөнддөггүй. Өөрөөр хэлэх юм бол одоо үйлчилж байгаа хуулиар 2001-3001, 3001-ээс дээш гэдэг үндсэн ангилал нь бол хэвээрээ байж байгаа. Яагаад гэхээр энэ өөрөө улсын хэмжээнд ингэж мөрдөгдөж байгаа ийм хууль учраас бид нар хуулийнхаа энэ зохицуулалт энэ интервалыг бол өөрчлөөгүй. Гагцхүү дээд хязгааруудыг нь одоо байдаг 16-48 гэдгийг нь 16-96, 18-54 гэдгийг нь 18-108, 22-66 төгрөг гэдэг нь 22-132 төгрөг гээд орон нутаг бодлогоо гаргаж, авто тээврийн өөрөө явагч хэрэгслээс авах татварынхаа бодлогыг өөрөө хэрэгжүүлэх бүрэн эрхийг нь илүү өргөтгөж өгч байгаа ийм зохицуулалт байгаа. Тэгэхээр нийслэл хот, НИТХ энэ

татвараа тогтоохдоо таны хэлж байгаагаар бага хөдөлгүүртэй машиндаа бол бага интервалаар, өндөр хөдөлгүүртэйгээр бол өндрөөрөө тогтоогоод явах боломж нь бол нээгдэж байгаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

2.Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. 2 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

3.Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. 2 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. 3 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Сандаг-Очир гишүүн байна. Сандаг-Очир гишүүнээр тасалъя. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Хотын дарга, шинэ даргын шинэ баг хамт олны бас хийх гээд байгаа ажлыг ойлгож байгаа. Бас бүрэн эрхийн хугацааны үлдэж байгаа богино хугацаанд Улаанбаатар хотын тулгамдсан түгжрэл, орон сууцжуулах гээд ажлуудыг бас хийх гээд явж байгааг ойлгож байна. Гэхдээ 1 ажлыг хийх гэж бас нөгөө мөрдөгдөж байгаа хуулийг зөрчиж гэдэг юм уу, ингэж хийж болохгүй. Тухайлбал та бүхний өргөн барьсан байгаа тендерийн хууль гээд хэлчихье. Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль.

Өнгөрсөн хаврын чуулганаар 6 сард нэмэлт, өөрчлөлт орж, хийсэн нэмэлт, өөрчлөлтийн гол үзэл санаа бол үндсэндээ тендерийн хуулийг хялбаршуулах, цахимжуулах, хүний оролцоог бууруулах, ил тод болгох энэ чиглэлээр хийгдсэн өөрчлөлт. Энэ нэмэлт, өөрчлөлт шинэ оны 1 сарын 1-ээс хэрэгжинэ. Гэтэл өмнөх нэмэлт, өөрчлөлт батлагдаад хэрэгжих хугацаа нь эхлээгүй байж байхад дараагийн нэмэлт, өөрчлөлтийг хийх гээд тэр тусмаа одоогийн мөрдөгдөж байгаа хууль дээр та бүхний оруулж ирснээр харахад ерөөсөө бараг нийслэлийн худалдан авах ажиллагааны бараг тодорхой, дийлэнх олон хувь нь тухайлбал хот тохижилт гээд. Хот тохижилтын дотор маш өргөн агуулгатай. Авто замын ажил. Тэгээд халаалт, цэвэр, бохир усны шугамын ажил. Үерийн далан сувгийн ажил, арчилгаа, хог хаягдалтай холбоотой

бараа, үйлчилгээ гээд бүгдээрээ. Машин техник тоног төхөөрөмжийг худалдан авах. Үгүй ээ, энэ бүх ажлуудыг тендергүйгээр хийхээр оруулж ирж байгаа нь энэ чинь арай бас яаруу яаруу гэхэд бас арай хэтэрхий байгаа юм биш үү. Эхний улаан, ногоон автобус, дан, давхар автобуснуудын асуудал дуусаагүй. Шүүх маргаантай явж байхад араас нь залгуулаад баахан хуулиар эрхийг олж аваад, тендергүй худалдан авалтуудыг хийх гэж байна шүү дээ. Энэ дээр манай Төрийн худалдан авах ажиллагааны газар юу гэж үзэж байгаа юм. Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар юу гэж үзэж байгаа юм энэ хуулийг. Одоогийн мөрдөгдөж байгаа хууль дээр хэдхэн шууд худалдан авалт хийхийг төрийн нууцад хамааруулсан ажил үйлчилгээнүүдийг шууд худалдан авалт хийхээр зохицуулсан байдаг. Хавар энэ хуулийг яригдаж байхад бас хэд хэдэн сайд нар өөрсдийнхөө ажлыг явуулах гэж энэ хууль руу хэд хэдэн ажлуудыг тендергүйгээр хийдэг байхыг санаархаж байсан. Энийг таслан зогсоож байсан. Гэтэл араас нь манай нийслэлийнхэн маань бараг одоо Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийдэг худалдан авах ажиллагааныхаа дийлэнх олгохыг нь үндсэндээ тендергүйгээр хийхээр оруулж ирэх гэж байна шүү дээ. Ингэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах энэ хуулийг, энэ том суурь хуулийг Түгжрэлийн хуулийг дагалдуулсан хуулиар оруулж ирж ингэж өөрчилж болохгүй ээ. Би бол энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжих боломжгүй байна. Тийм учраас зарчмын зөрүүтэй санал гаргаж, энэ заалтыг буцаах саналтай байна гэдгээ хэлье.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн саналаа хэллээ. Асуулт асууж байгаа биш, зарчмын зөрүүтэй санал гаргана гэсэн. Дэлгэрсайхан сайд тайлбар хэлж болно. Дэлгэрсайхан сайдын микрофоныг өгье.

Б.Дэлгэрсайхан: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Нийслэл хотын хот тохижилт, авто зам, халаалт, цэвэр, бохир усны шугам, үер, далангийн сувгийн засвар, арчилгаа, хог хаягдал гээд энэ яагаад ингээд нэг удаадаа шууд худалдан авалт хийе гэж оруулж ирж байгаа юм бэ гэхээр зэрэг далан шугам задрах та өөрөө мэдэж байгаа, халаалт гэнэт энд тэнд задрах ийм юманд бид сая энэ зун өөрсдөө үер даланг үзээд харлаа шүү дээ. Тэгэхээр ийм юм дээр бид нар тендер хүлээгээд сууж байх 1 дүгээрт ийм боломж байхгүй ээ. Та энийг бас зөв ойлгоорой. Ялангуяа одоо цэвэр бохир усны шугам хуучирсантай холбогдуулан энд тэнд задрах явдал бол маш их гарч байгаа. Нийслэл дээр. Тийм учраас энэ дээр бас энэ бүгдийг бодолцож энийг нэг удаа ингэж хэрэглэе, тэгээд дараа Түгжрэлийн хуультай холбоотой жишээлбэл та юуг хэлж байх шиг байна. Нийслэл хотын объект талбайгаар нь ашиглалт и, засвар үйлчилгээ хариуцсан гээд. Бид нар нөгөө орон сууцжуулах буюу Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулахтай холбогдсон шинэ хууль өргөн барьж байгаатай холбогдуулан энэ хуулиа 2024 оны 1 сарын 1-ээс хэрэгжүүлэхтэй холбогдуулж бэлтгэл ажил хийх гэж байгаа юм. Жишээлбэл, зогсоол дээр янз бүрийн тоног төхөөрөмж яаралтай худалдаж авч тавих, мөн бүсчилж байгаа зарим хэсэг дээр юу тавих өнөө юу гэдэг билээ нөгөө камержуулах энэ тэр гээд зайлиггүй урьдчилж хийх ийм ажлууд байгаа учраас л энийг нэг удаад нь оруулж ирж байгаа юм шүү гэдгийг бас зөв ойлгоорой. Тэрнээс биш дахин дахин ийм юм гарахгүй байх гэж бодож байна. Шинэ хууль өргөн барьж байгаатай холбогдуулан зайлиггүй ийм хийх юмнууд гарч ирээд байгаа юм.

Дараагийн дугаарт тэр машин механизм, тоног төхөөрөмж, бараа худалдан авах гэдэг дээр лизингээр авна гэдэгт юу хамааруулаад байгаа юм

гэхээр жишээлбэл өнөөдөр Улаанбаатар хотод цасны машин. Давсыг хүртэл гараараа цацаад явж байна шүү дээ. Бид нар чинь. Ийм ичгүүртэй байдалд амьдарч байна шүү дээ. Тэгэхлээр ийм машинуудыг ид хүйтэнд тендер зарлаад хүлээх юм бол өнөөдөр ингээд автобустай адилхан шүүмжлүүлээд сууж байгаа. Тийм учраас ногоон автобуснаас болоод бид автобусны тендерийн өнгөрсөн сарын 24-нд зарласан. Бүтэн сар хүлээгээд нөгөөдөр энэ тендер задрах гэж байна. Тэгээд нийслэлчүүд юу гэж хэлж байна вэ гэхээр автобус хаачсан юм бэ, автобус хэзээ орж ирэх юм бэ гээд асуугаад байдаг. Тэгээд бид нар энэ бүгдийг тендерийн хуульдаа баригдаад яаж ч чадахгүй байгаа юм. Арга буюу энийг оруулж ирж байгаа юм. Тэрнээс ямар нэгэн хулгай хийж, худлаа хэлэх, мэдээж хардлага сэрдлэг байх нь зөв. Тэгэхдээ ямар нэгэн тийм юм байхгүй. Энэ бол зайлшгүй хийгдэх гээд байгаа зүйл шүү гэдгийг хэлье. Энийг бас зөв ойлгоорой. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Ойлгож байгаа тийм. Гэхдээ үер ус, зуд турхан гээд цаг үеийн шинжтэй ажлууд тухайн үеийнхээ тэр онцгой байдлынхаа хуулиар, тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн тэр нөөцөд байдаг тэр хөрөнгө оруулалтаас шууд гаргаад шийдээд явах эрх нь бол байгаа юм. Энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль бол өөр. Харин ч эрх бүхий албан тушаалтнуудыг шоронд орохоос нь урьдчилан сэргийлж байгаа хууль шүү. Ер нь бол эндээс хамгаалж байгаа, урьдчилан сэргийлж байгаа санал байгаа юм. Хэрвээ дур дураараа яаралтай хийх ажил, шаардлагатай байна гээд энэ болгоныг 1 удаагийн шинжтэй хуулиар эрхийг нь шууд худалдан авалт хийхээр энэ чинь тэгвэл энэ хууль байгаад ч хэрэг алга. Тийм учраас би бол энийгээ та

бүхэн эргээж хараач ээ энэ уулиа гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн санал хэллээ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад Сандаг-Очир гишүүн зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргая гэсэн. Өөр саналтай гишүүд байгаа юу. Алга байна Сандаг-Очир гишүүнээр тасалъя. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Би зарчмын зөрүүтэй саналаа зарчмын зөрүүтэй саналын хуудсан дээр бэлдчихсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажилгүй худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргалаа. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналын томъёоллыг гаргаж байна. Засгийн газар сайд нараа дуудаарай. Санал хураалт явагдана. Сандаг-Очир гишүүн бол зарчмын хувьд зарчмын байр суурь илэрхийллээ гэж харж байгаа. Дөнгөж энэ онд Улсын Их Хурал Төсвийн байнгын хороо дээрээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд ажлын хэсэг ажилласан. Ажлын хэсгийн ахлагчаар манай Сандаг-Очир гишүүн ажилласан байгаа. Тэгэхээр та бүхний оруулж ирсэн хуулийн төсөл дээр 34.1.3 дээр шууд гэрээ байгуулах эрхийг нийслэлд олгохоор зааж оруулсан байна. Тэгэхээр уг нь шууд гэрээ байгуулах үндсэн суурь зарчим нь хууль дээр туссанаараа зөвхөн гамшиг болоод онцгой нөхцөлд, магадгүй давагдашгүй хүчин зүйл үйлчилсэн

тохиолдолд шууд гэрээ байгуулж болно л гэсэн суурь зарчим тендерийн тухай хууль дээр заасан байдаг. Тэгэхээр бид нарын тендерийн тухай хуулийн үндсэн суурь зарчим маань аль болох л худалдан авах үйл ажиллагааг үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай, ил тод, нээлттэй байдлаар хийх л гэсэн зарчим гараад байгаа юм. Тэгэхээр бид нар өмнөх олон худалдан авалттай холбоотой олон юу гэдэг юм гэмт хэргийн шинж чанартай асуудлуудтай холбогдуулж ер нь бол уул нь суурь тендерийнхээ хуулийн зарчмыг баримтлах ёстой гэсэн хувь хүний бас байр суурьтай байна. Тэгэхээр Сандаг-Очир гишүүний гаргасан саналын томъёоллыг дахиж уншиж танилцуулъя.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулах нь байна. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт 40 хувиар дэмжигдсэнгүй.

Төсвийн байнгын хороо Төрийн байгуулалтын байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлэх учиртай байгаа шүү. Санал, дүгнэлт дээр энийг протоколоор онцгойлж тусгаж Төрийн байгуулалтын байнгын хороонд санал, дүгнэлтийг хүргүүлэхдээ энэ саналыг онцгойлж үзэхийг Төрийн байгуулалтын байнгын хороонд бас даалгах учиртай шүү.

2 хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу? Зарчмын зөрүүтэй санал гаргах Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: 2 дугаар зүйлийг бас ойлгохгүй байна. Энэ чинь мэргэжлийн холбоонд бас гэрээний үндсэн дээр тендер сонгон шалгаруулалтад оруулах эрхийг өгөх гэж

байна. Энэ ямар утгатай, ямар заалт юм. Юун дээр нь ямар ач холбогдолтой юм энэ нийслэлийн түгжрэлийн ажилд. Өчнөөн олон төрийн бус байгууллагууд байгаа шүү дээ. Мэргэжлийн холбоод байгаа шүү дээ. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах. Энийгээ нэг нийслэлийнхэн тайлбарлаж өг дөө. Энэ 2 дугаар заалтаар ямар том үүд хаалгыг нээж өгч байгаа вэ гэдгээ нэг тайлбарлаад өгчих.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг 4 номер.

Д.Цолмон: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Нийслэлийн Засаг даргын ахлах зөвлөх Цолмон байна. Энэ тендерийн хуулийн худалдан авах ажиллагааны тодорхой чиг үүргүүдийг мэргэжлийн холбоодоор юм уу Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг оруулж ирж байгаа. Шинэ тендерийн хуулийн 2023 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхлэх шинэ тендерийн хуулийн концепт дээр бол энэ асуудал бас тусгагдсан байгаа. Үүн дээр юу гэж тусгасан бэ гэвэл тодруулбал, 49 дүгээр зүйл дээр худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага гэдэг ийм зүйл заалт дээр Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэх бөгөөд яг энэ хүрээндээ тодорхой чиг үүргүүдийг бол заагаад өгчихсөн байгаа. Тухайлбал тухайн цахим системийн үйл ажиллагаа худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлаар захиалагч оролцогчийн мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах, ерөнхий гэрээ байгуулахтай холбоотойгоор хуульд заасан захиалагчийн эрхийг хэрэгжүүлэх, тендерийн баримт бичгийг бэлтгэж бүрдүүлэх, цахим системийн ашиглалт, худалдан авах ажиллагааны талаар сургалт зохион байгуулах гэх мэтчилэн үүргүүдийг тодорхой чиг үүргийн

мэргэжлийн байгууллага буюу иргэний нийгмийн байгууллагад шилжүүлж болно гэсэн энэ зохицуулалт бол одоо шинээр хэрэгжиж элэх гэж байгаа Худалдан авах ажиллагааны хууль дээр бол байгаа. Тэгээд үүнийг бол 2025 оны худалдан авах ажиллагааны хууль дээр оруулж ирж 1 сарын хугацаанд л тодорхой хэмжээнд энэ эрхээ авч тендерийн баримт бичиг боловсруулах, сургалт зохион байгуулах, захиалагчийн зарим эрх, үүргээ хэрэгжүүлэх энэ эрхээ мэргэжлийн холбоодод шилжүүлэх ийм л зохицуулалт бол орж ирсэн байгаа. Ерөнхийдөө 1 сарын 1-ээс шинэ хууль хүчин төгөлдөр мөрдөгдөөд ирэхээр боломж нь угаасаа бол нээгдэж байгаа гэж ойлгож байгаа.

Г.Тэмүүлэн: Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

5.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. 5 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн. Батжаргал гишүүн байна. Батжаргал гишүүнээр тасалъя. Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Хуулийн 1 дүгээр зүйлийн тэр 29.1.4 дэхийн орон нутгийн гэдгийг нэг тайлбарлаад өгөөч. Орон нутагт такси үйлчилгээ тэмдэгтийн хураамж 5-10 сая төлөх юм бол угаасаа тэр үйлчилгээнүүд бүгд тарж унана. Энэ ямар утга учиртай ийм үг орчхов.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Ийм учиртай юм. Сүүлийн үед хүн болгон такси үйлчилгээ хийдэг болчихоод байгаа юм. Зүүн гарын хүрдтэй ч бай, баруун гарын хүрдтэй ийм машинууд. Тэгэхлээр хүн болгон такси үйлчилгээ хийсэнтэй холбогдуулаад би түрүүн хуулийн төсөл өргөн барьж байгаа энэ юун дээр уншсан шүү дээ. Энэ такси машины үйлчилгээтэй холбогдуулаад гарч байгаа гэмт хэргийн тоо маш их болсон. Тийм учраас энийг цэгцлэх үүднээс бүртгэлтэй жишээлбэл энэ зөвшөөрлийг нь бас нэг томоохон бас аж ахуйн нэгж тендер шалгаруулах журмаар ч юм уу өгөөд, эсвэл төр-хувийн хэвилийн түншлэлээр ч юм уу, эсвэл лизингээр ч юм уу нөгөө томхон аж ахуйн нэгж ороод ирвэл хүмүүсийг бас нэг UB Cab нөгөө бид нарын ярьдгаар юу юу билээ. Uber тиймэрхүү үйлчилгээг бий болгож, эзэнтэй болгохгүй бол одоо гарч байгаа гэмт хэрэгтэй холбогдуулаад ямар ч эзэн байхгүй. Ялангуяа орон нутгаас орж ирж нийслэл Улаанбаатар хотод такси үйлчилгээ хийх явдал бол газар авсан. Тэгээд гэмт хэргийн үүр уурхай болоод, хүчирхийллийн хэрэг, дээрмийн хэрэг энэ тэр бол бүгд дандаа такситай холбоотой гарч байгаа. Тийм учраас л энэ дээр бас нэг ийм юм оруулсан юм гэж тайлбар хиймээр байна.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн нэмж тодруулъя.

Ж.Батжаргал: Бүртгэл, хяналт, зохион байгуулалт эд нар нь бол тусгай хуулиар зохицуулж болох байх. Энийг бол хийх ёстой зөв. Үгүй ээ, орон нутагт ер нь такси үйлчилгээ эрхлээд ямар орлого олдог юм гэдэг юм чинь л өөрөө гарч ирнэ шүү дээ. Олдог орлогоос нь давчихсан хураамж авчихаар чинь тэнд мянган чадалтай компани ороод ч хэрэггүй шүү дээ. Тэгэхээр зэрэг энэ хөдөлгөөний эрчим өндөртэй хүн ам ахиутай Дархан, Орхон,

Улаанбаатар гэдэг юм уу ийм газруудад болно. Говьсүмбэрт такси үйлчилгээ эрхлээд ийм орлого олох уу. Үгүй ээ, энэ чинь амьдрал их сонин эд байхгүй юу. Тэгээд үндсэндээ зүгээр ард иргэдэд үйлчилж байгаа үйлчилгээг зөвхөн энэ хураамжийн асуудлаар болоод устгаж байгаа байхгүй юу. Яг нарийндаа. Хүндрэл түвэгшилтийг бий болгоно. Тэгэхээр энийгээ нэг.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг хариулъя. 3 номер.

П.Сайнзориг: Батжаргал даргын бас хэлж байгаа зүйлүүдийг бид бас ажлын хэсэг дээр бас анхаарч ярилцъя. Тэгэхдээ энэ удаагийн улсын тэмдэгтийн хураамжийн тэр 5-10 сая гэдэг бол нэг л удаагийн хураамж байхгүй юу. Зөвшөөрлөө авахдаа л бүрдүүлж байгаа хураамж. Түүнээс биш юу гэдэг юм. Өдөр тутам ч юм уу ийм зүйл авах гээд байгаа зүйл биш. Тэгэхээр бас тодорхой хэмжээний нийтийн тээвэр буюу автобус таксинь асуудлыг тодорхой хэмжээнд зохицуулалттай явуул гэдэг зүйлийг бас Засгийн газар дээр бодлогын түвшинд яригдаж байгаа учраас уг асуудал орж ирсэн. Түүрүүн бас Дэлгэрсайхан сайд хэллээ. Такси үйлчилгээг дагасан олон гэмт хэрэг зөрчлүүд гарч байгаа. Үйлчлүүлэгч нь хохирохоос гадна таксинд яваад байгаа иргэд маань хүртэл өөрсдөө амь насаа алдах, хүчиндүүлэх ч гэдэг юм уу ийм олон асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр бид хэд энэ асуудлыг зөв зохион байгуулалтад оруулъя. Такси үйлчилгээ гэхээр нөгөө авто баазтай ч юм уу ийм нүсэр зүйлийг бид нар бас бодохгүй байгаа юм. *UB Cab* шиг программ хангамж буюу иргэдийг нэгтгэсэн ийм байдал дээр такси үйлчилгээг зөв зохион байгуулах боломж бол байгаад байгаа юм.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр яах вэ, сая ийм асуудал хөндөгдөөд байна шүү дээ. Одоо 29.1 чинь яг аж ахуйн нэгжүүд дээр улсын тэмдэгтийн хураамж хураах

л зохицуулалттай асуудал. Тэгээд та бүхний ярьж байгаа тайлбар чинь нэг талдаа бид нар яах вэ, энэ дээр нэмэх нь аж ахуйн нэгжүүд дээр 5-10 сая төгрөгийн ийм төлбөр авна гэдэг асуудал яригдаад байгаа юм. Батжаргал гишүүн бол сая ярьж байгаа чинь орон нутагт ийм өндөр байхад чинь нөгөө орлогоосоо давсан ийм тэмдэгтийн хураамж авах гээд байгаа асуудал юм биш үү. Бизнес эрхлэх тэр аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулах эрхийг нь хаачих вий дээ гэсэн асуудал байгаа юм. Тэгэхээр эдийн засгийн тооцоолол, үндэслэл талаас нь судалж үзээч үзээч гэсэн санал байгаа юм. Тэгэхээр энийг та хэд ч гэсэн бас аж ажлын хэсэг дээрээ байна уу, хэлэлцүүлгийн явцад анхаарах нь зөв байх. Дээрээс нь та бүхний тайлбарлаад байгаа 29.1.4-ийг оруулснаараа бид нар бол саяын юу гэдэг юм, гэмт хэрэг үйлддэг, хувиараа таксинд явдаг хувь хүн үйлчилгээнд явдаг зүйлийг хаах гэж байгаа юм гэсэн маягтай тайлбар өгөөд байна шүү дээ. Хаах гэж байгаа биш, цэгцэд оруулах юм уу. Тэгэхээр уг нь тэрийг бол бүр журмаараа ч гэдэг юм уу зохицуулалт хийгээд, эсвэл та хэд маань л анхаарч үзээрэй. Яг орон нутагт энэ үйлчлэл чинь яг боломжтой юу, боломжгүй юу. Эсвэл шаардлагатай бол зөвхөн Улаанбаатар нийслэл хотод ч гэдэг юм уу, төв суурин газрууд гэдэг юм уу хүн амаас нь хамаарч л хийхгүй бол магадгүй сум орон нутгийн онцлогууд ч бас өөр өөр байгаа шүү дээ. Бага хүн ам төвлөрсөн суурьшлын бүс багатай мөртөө такси үйлчилгээ явдаг аж ахуйн нэгжтэй гээд ийм л саналыг хэлээд байна шүү. Тэгээд та бүхэн анхаарч үзээрэй. Гишүүдийн хэлж байгаа саналыг.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Сая зарчмын зөрүүтэй санал гаргасангүй гэж ойлголоо.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. 3 арчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух болон зарчмын зөрүүтэй...Батжаргал гишүүн 3 дээр байгаа юм байна.

Ж.Батжаргал: Би тэр зарчмын зөрүүтэй санал гаргахгүй. Та хэд ажлын хэсэг дээрээ ярина биз дээ. Авто тээврийн хэрэгсэлд техник хяналтын үзлэг гэдэг техник хяналтын үзлэг гэдэг чинь оносон нэр мөн үү, биш үү гэдэг асуудал. Би тэр нэг оношилгоо үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлж байгаа юунуудыг юм байна гэж ойлгоод байна. Тэгээд тэр талаасаа наад үгээ онох тухай асуудал байна. Дахиад орон нутагт яг ийм байгууллага дээр хэчнээн тээврийн хэрэгсэл очиж оношлогддог юм гэдэг асуудал байхгүй юу. Тэгэхээр зэрэг 15 сая төгрөгийн төлбөр төлөөд тусгай зөвшөөрөл авдаг тийм оношилгооны цэгүүд ер нь яадаг бол. Үүнийгээ бас судалгаан дээр л тулгуурлах ёстой. Би бол өнөөдөр шууд хэлчээ ч чадахгүй байна үнэнийг хэлэхэд. Тэгэхээр энэ жижиг суурин газруудад чинь гэмт тарих вий.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний хэлж байгаа саналыг ажлын хэсэг бас анхаарч үзээрэй.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна. 4 дээр асуулт асуух гишүүн байна. Раднаасэд гишүүн байна.

Ш.Раднаасэд: Сайнзориг оо, энэ ажлын хэсгийг нь хариулах юм уу. 5-15 гэдэг чинь байршилаас нь хамаарч та нар төлбөрийн хэмжээ тогтоох гээд байгаа юм байгаа биз дээ. Улаанбаатар хотод гэхэд хотын төвд бол тэр, энэ дүүргийн А бүсэд бол тэр, Б бүсэд бол тэр ч гэдэг юм уу. Зөв үү. Одоо энэ үзлэг оношилгоо

ч гэсэн бас тэгэх юм байгаа биз дээ. Үгүй ээ, жишээлбэл 3 дугаар хороололд байгаа оношилгоо бол бөглөрөл тэрнээс 15 ч гэдэг юм уу, эсвэл бүр хотын захад байгаа нь. Тэр хэрээрээ энэ чинь нөгөө үйлчилгээний хураамж чинь багасах юм биш үү. Миний ойлгож байгаа зөв ойлгоод байна уу, буруу ойлгоод байна уу.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулах уу. Раднаасэд гишүүн асуултад ажлын хэсэг хариулаарай. Хэдэн номер вэ. Гараа өргөөрэй. 3 номер сайн. Сайнзориг дарга.

П.Сайнзориг: Энэ автотээврийн хэрэгслийн техник хяналтын үзлэг хийх үйл ажиллагааг. Тусгай зөвшөөрөлтэй этгээдүүд эрхэлдэг юм байна лээ. Одоогийн тусгай зөвшөөрлүүдийг Зам, тээврийн хөгжлийн яамнаас зөвшөөрөл авсан этгээдүүд бас авдаг. Тэгэхээр ер нь зүгээр тавьж байгаа нь интервалтай тавьж байгаа нь бол тухайн нөхцөл байдалдаа тааруулаад хуульд бас олон дахин хүрээд яах вэ гэдэг үүднээс л 5-15 сая төгрөгийн интервал дунд энэ тусгай зөвшөөрлийг олгохдоо 1 удаадаа л хураамж авах асуудал. Улсын тэмдэгийн хураамж. Түүнээс тогтмол авах гээд байгаа зүйл биш. Ерөнхийдөө улсын тэмдэгтийг нэг л удаа төлдөг, гэрчилгээ авахдаа буюу тусгай зөвшөөрөл авахдаа. Энэ хүрээндээ л тушаах мөнгө гэж бас ойлгож болно. Интервалыг бүсчлэх асуудал бол байхгүй байгаад байгаа. Энэ бол өөрөө эргээд мэдээж яг тухайн шийдвэрийг гаргах этгээдийн л одоо асуудал, доод тал нь 5 саяар төгрөгөөр тогтоож болно, дээшийгээ хүргэе гэвэл 15 сая хүртэлхээр тогтоолгож болох. Тэгэхээр энэ хүрээндээ л интервалыг харгалзаж тогтоох ийм асуудал байгаа юм.

Г.Тэмүүлэн: Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулаад зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух болоод

зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

6.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. 3 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Батжаргал гишүүн байна. Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Энэ дагасан хуулиуд л даа. Тэгээд Үндсэн тэр анхдагч хуульдаа төлбөртэй бүсээ байхгүй болгосон гээд сайд тэгж хариулсан. Тэгвэл дагасан хуульд Төсвийн тухай хуульд байдаг энэ 23.6.11-ийг авах ёстой бид. Тэгэхээр ажлын хэсэг энэ хууль хоорондын нийцэл хангаж оруулж ирэх асуудал жоохон дутагдалтай байна шүү нөхөд өө. Тэгээд яах гэж оруулж ирээд байгаа юм тэгвэл. Тэгвэл заавал бид нараар тоглоом хийж нэгдлээ хангаагүй, хэлэлцээгүй юмаа оруулж ирж хэрүүл өдөж байх ямар хэрэг байгаа юм. Та нарын тоглоом юм уу. Энийгээ авах ёстой 1. 2 дахь зүйл тэр ард гарч ирээд байгаа юм. Тэр үл хөдлөх хөрөнгийн татвар дээр ногоон байгууллага, цэцэрлэгт хүрээлэн нь стандарт хангаагүй бол үл хөдлөх хөрөнгийн татварыг 1 функтээр ахиу төлнө гэж. Стандарт хангаагүй цэцэрлэгт хүрээлэнгээр үлийгээ хийдэг юм. Түүнийгээ стандарт л хангуулаач дээ. Тэгээд хуулиар бид зөвшөөрч байна шүү дээ. Стандарт бус ногоон байгууламж цэцэрлэгт хүрээлэн байхыг. Ийм эрх зүйн зохицуулалт гэж байдаг юм уу.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг 3 номер.

П.Сайнзориг: Батжаргал гишүүн ээ, ийм юм байна лээ. Энэ хууль маань нөгөө Төрийн байгуулалтын байнгын хороо дээр байгаа. Тэгэхээр нөгөө холбогдох Байнгын хороодоор энэ дагасан хуулиудын анхны хэлэлцүүлгийг

нь хийж байгаа гэж ойлгож байгаа. Энэ хуулийн дараа бас том ажлын хэсэг хуралдаад, Төрийн байгуулалтын байнгын хороо бас анхны хэлэлцүүлэг хийнэ. Тэр дээр энэ саналын томьёоллууд Байнгын хороод бас ирсэн саналыг бас хураалгаад явах ийм дэгтэй. Энэ дэгийн дагуу явж байгаа гэж ойлгож байгаа.

Энэ үл хөдлөх хөрөнгийн албан татвар дээр бол бас нэмэгдүүлээд ногоон байгууламжгүй, авто зогсоолгүй ийм үл хөдлөх хөрөнгө дээр оногдуулж байгаа татварын 1 хувиар нэмж бас татвар ноогдуулах асуудал байгаа. Тэгэхээр нэгэнт магадгүй яах вэ улсын комисст өгөхдөө энэ стандартаа бариад явчихдаг, дараа нь ногоон байгууламжаа буулгаад барилгажуулж болохгүй ээ л гэдэг санааг бид нар хөшүүргийг нь оруулж өгч байгаа. Тэгэхээр аливаа зүйлүүдийг стандартыг мөрдүүлэхийн төлөө бид байгаа. Энэ мөрдүүлдгийг бас хөшүүрэг нь бол эдийн засгийн аргаараа байхгүй бол хэн нэг этгээд юу гэдэг юм байнгын очоод л акт тавиад л, энийгээ эсвэл стандартын шаардлага хангаж ингээж янзална, буулгана гээд хэлээд байж болохгүй. Тэгэхээр бид хэд энэ эдийн засгийн хөшүүрэг тавьж байж цаашидаа барилгын өмчлөгч буюу барилга барьж байгаа компаниуд маань аливаа зүйлийг стандартын шаардлага хангаж барих ийм эдийн засгийн хөшүүргээр л зохицуулалт хийх ийм оролдлого хийж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Би бас дахиад тодруулаад асуугаадахъя. Сая Батжаргал гишүүний яг хөндөөд байгаа асуудал нь зарчмын л асуудал хөндөөд байх шиг байна. Би яах вэ, зүгээр хууль зүйн талаасаа. Татварын ерөнхий хууль дээр чинь үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар гээд угаасаа заачихсан байгаа. Тэгээд тэр дээр зааснаараа бол 0,6-2%-аар Улсын Их Хурлаас тогтоосон. Татварын ерөнхий хууль дээр бол. Тэгэхээр юу гэдэг юм яг хязгаарт нь багтаагаад Улсын Их Хурлаас баталсан хязгаарт л тогтоодог болох ёстой

болчхоод байгаа. Би зүгээр яг Татварын ерөнхий хууль дээр суугаагүй харилцаа маань дахиад ингээд юу гэдэг юм орж ирж гэдэг юм уу, эсвэл нийслэлд Улсын Их Хурлын татвар тогтоох эрхэд нь нэг талдаа бас халдаж нийслэл юу гэдэг юм татвар тогтоодог болох ч гэдэг юм уу энэ зарчмын хувьд ер нь зөв юм уу. Хууль зүйн бичилт талаасаа. Хэрэв үнэхээр одоо энэ хууль, энэ шинэ нэмэгдэл татварыг бий болгох шаардлагатай гэж үзэж байгаа бол үл хөдлөх эд хөрөнгийнхөө албан татварынх нь хуулиар тогтоосон дээд хувь хэмжээг нь нэмэгдүүлээд, татварынхаа ерөнхий хууль дээр хуулийнхаа нийцэлтэйгээ нийцүүлээд холбогдох өөрчлөлтийг нь оруулаад хийх нь зөв юм биш үү л гэсэн санал байгаад байгаа юм. Сайнзориг 3 номер.

П.Сайнзориг: Тэмүүлэн даргын асуултад хариулъя. Тэгээд бид хэд энийг бас ажлын хэсэг дээрээ нэлээн нухацтай бас ярилцъя. Тэгэхдээ өнөөдрийн Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6.1 дээр ийм харилцаа байгаа юм. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан үнэлгээнээс аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн хөрөнгийн байршил, зориулалт, хэмжээ, зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн байдлыг харгалзан 0,6-2%-аар тооцож ноогдуулна гээд. Яг энэ 6.1 гэсэн заалтын доор 6.2-оор стандартын шаардлагад хангаагүй буюу ногоон байгууллага нь авто зогсоолгүй дээр оногдуулж байгаа энэ татвар дээр 1 хувиар нэмэгдүүлж бас авъя л гэж байгаа юм. Энэ татварынх нь 1 хувиар. Өөрөөр хэлэх юм бол та 6.1-ийг жишээ нь өсгөчихье гэхээр энэ бүгдэд нь хамаатай болоод явчхаж байгаа байхгүй юу. Нөгөө стандартын шаардлага хангаж байгаа үл хөдлөх хөрөнгүүдээр ч гэсэн нэмэгдүүлж авах орон зайг нь өгчхөж байгаа учраас нөгөө яг ногоон байгууламжтай, авто зогсоолтой үл хөдлөх хөрөнгүүдийн өмчлөгч нарт бол халгаатай гэх юм уу тэд нарын бас татварын ачаалал нэмэгдэх учраас энийг

нь ингэж тусдаа техникээр 6.2 дээр бид хэд бол бичсэн байж байгаа. Тэгэхдээ таны саналыг бид нар бас ажлын хэсэг дээр нэлээн сайтар ярилцъя гэж бодож байна. Тэлмүүн дарга та нэмж хэлэх юм байгаа болов уу. Дарга зөвшөөрвөл бас Сангийн яамны байр суурийг бас сонсчихвол гэж.

Г.Тэмүүлэн: Би тэгвэл Сангийн яамнаас бүүр нэмээд тодруулаад асуугаадахъя. Одоо энд Төсвийн тухай хууль дээр ингэж байгаа юм. 2 төлбөр орж ирж байгаа юм. 1 төлбөр, 1 татвар орж ирж байгаа байхгүй юу. 23.6.11, 23.6.12 замын хөдөлгөөний төлбөртэй бүсийн төлбөр гэж нэг нэмж байна. Хоёрдугаарх нь Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6.2-т заасны дагуу нэмэгдүүлж ноогдуулах албан татвар гэж нэмж байгаа юм. Тэгэхээр яг ийм шинэ төлбөр, татвар тогтоож байгаа тэр чинь Татварын ерөнхий хууль дээр байх ёстой биз дээ. Монгол Улсад мөрдөгдөж байгаа хуулийн дагуу бүх төлбөр хураамж, татварыг Татварын ерөнхий хуулиар зохицуулж гэж байгаа. Гэтэл Татварын ерөнхий хууль дээр байхгүй 2 шинэ нэр төрлийн төлбөр, татварыг Төсвийн тухай хууль дээр оруулж ирээд байгаа байхгүй юу. Тэгэхээр агуулгын хувьд юу гэдэг юм яагаад Төсвийн тухай хууль дээр шинэ нэр томъёо, шинэ төлбөр, шинэ татварыг бий болгоод байгаа юм бэ. Үнэхээр юу гэдэг юм, та бүхэн төлбөр, татвар байх ёстой гэж үзэж байгаа бол хууль зүйн бүрдэл, нийцэл талаасаа энэ чинь Татварын ерөнхий хууль дээрээ өөрчлөлтийг нь хийх ёстой шүү дээ. Тэгэхээр энийг жишээ нь Сангийн яам яагаад зөвшөөрсөн юм. Тэлмүүн дарга та энэ дээр нэг хариулаач. Одоо яг энэ зүйл 23.6 чинь ерөнхийдөө орон нутагт нь үлдээх л зохицуулалтын л харилцаа байгаа болохоос биш 23.6 дээр чинь юу гэдэг юм ямар нэг шинэ татвар ноогдуулж бий болгож байгаа ч гэдэг юм уу тийм харилцааг зохицуулсан харилцаа бол тэнд байхгүй шүү дээ. Сангийн яам хариулъя 6 номер.

Б.Тэлмүүн: Тэмүүлэн даргын асуултад хариулъя. Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйл бол аль татвар нь аль төсөв рүүгээ орох орлогын хуваарилалтыг зохицуулж байгаа. Одоогийн хуулиар бол 23.8.16 дээр бол үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар нь бол сумын орлого руу орно гээд орж байгаа. 23.6.12 буюу энэ үл хөдлөх хөрөнгийн албан татварын тодорхой хэсэг нь нийслэл, аймгийн төсөв рүү орохоор ингэж зохицуулсан. Энэ бол шинэ төрлийн татвар үүсгэж байгаа хэлбэр биш. Төсвийн тухай хуулиар энэтэй холбоотой улсын тэмдэгтийн хураамжийн ийм томъёолол бол байдаг. Тухайлах юм бол, 23.4.9 дээр Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 11.2-т заасан улсын тэмдэгтийн хураамж нь улсын төсөвтөө орно. 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж нь орон нутагт орно гээд. Нэг татварын хуулийн ногдож байгаа харилцааг зарим нь улсын төсөв рүү, зарим нь аймаг руу, зарим нь нийслэл рүү, зарим нь сум руу, дүүрэг рүү гэж явах бол техник бол байдаг. Тэгэхээр энэ дагуу бол Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуулийн орлогын хуваарилалтыг бол томъёолсон байгаа. Замын хөдөлгөөний төлбөртэй бүсийн төлбөрийг бол хууль санаачлагчаас бол болих гэдэг юугаа л илэрхийлсэн байгаа. Тэгэхээр энэ бол хасагдаад явах байх гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Одоо энэ дээр чинь ч юу гэж тайлбарламаар юм бэ дээ. Яг л төсвийн хууль дээр чинь наад 23.6-д чинь ерөөсөө л орлогын хуваарилалт байгаа байхгүй юу. Тэгээд орлогын хуваарилалт дээр та бүхэн аваачаад шинэ татвар, төлбөрийг үүсгэхээд байдаг. Татварын ерөнхий хууль болоод бусад юу гэдэг юм татвартай холбоотой хуулиуд дээр та бүхний оруулж байгаа энэ шинэ нэр томъёо чинь байхгүй байгаа. Тэгэнгүүт байхгүй нэр томъёог орлогыг нь хуваарилах гээд зохицуулалт хийгээд байгаа чинь хууль зүйн талаасаа буруу

болчихоод байна л гэдэг санааг би хэлээд байгаа шүү. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Хэдүүлээ маргаад яах вэ, 23.6.11-ийг бол тэртээ тэргүй ажлын хэсэг дээрээ яриад та хэд зохицуул. Тэртээ тэргүй тэр анхдагч хууль дээрээ авчхаад байгаа юм байна лээ. Хасчихаж байгаа гэж ярьсан шүү дээ түрүүн. Наад 23.6.12 чинь байна шүү дээ. Нэг аж ахуйн нэгжийн асуудал биш ээ. Орон сууц барьчихсан компани барилгаа дуусаад стандарт хангаагүй барилгаа тууз хайчлаад, айлуудад зарчихна аа. Тэгж барьсан хүний төлбөрийг айл төлөөд сууж байх юм уу. Юу гэсэн утгатай үг юм наадах чинь. Та хэдийн ярьж байгаа юм тийм л юм ярьж байна шүү дээ. Хэн нэгний буруутай үйл ажиллагааг нэг хэсэг хүмүүс төлөөд сууж байх юм уу. Хаашаа юм. Зохицуулж байгаа харилцаа чинь тэгж зохицуулагдаад байна шүү дээ. Энэ юмнуудыгаа нэг жсоохон задалж унивал яасан юм бэ дээ.

Г.Тэмүүлэн: 3 номер ажлын хэсэг.

П.Сайнзориг: Батжаргал даргын асуултыг бид хэд бас ойлголоо. Тэгээд ажлын хэсэг дээрээ сайн ярья. Яах вэ зүгээр орон сууц дээр бол таны хэлж байгаа зарчмаас өөрөөр байдаг. Өөрөөр хэлэх юм бол дараах үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас чөлөөлнө гээд Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйл дээр байж байгаа. Энд нь орон сууц өөрөө угаасаа ордоггүй байгаа. Тэгэхээр энэ бол юу гэдэг юм орон сууц өмчлөгч дээр ирж ийм зүйл нэмэлт татвар болох гээд байгаа зүйл байхгүй. Угаасаа татвар, үл хөдлөх хөрөнгийн татвараас чөлөөлөгддөг. Харин зүгээр бизнесийн чиглэлийн үйл ажиллагаа буюу одоо стандартаа барихгүй барилга байгаа боломжууд л энэ дээр нэмэгдэж орж ирэх болов уу гэж бид нар бас харж байгаа юм. Тийм ээ, тийм. 70/30-ийн харьцаатай байгаа.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн нэмж тодруулъя.

Ж.Батжаргал: Хаана байх нь хамаагүй ээ, энэ бид нар стандарт бус үл хөдлөх хөрөнгийг бий болгохыг хуулиар нээж өгч байгаа асуудал байхгүй юу. Төлбөрийг нь нэмэгдүүлэх замаар тэгүүлж болохгүй байхгүй юу. Тэр айл өрхүүд үл хөдлөх хөрөнгийн татварын 90%-ийг ч билүү хөнгөлөгддөг. Гэтэл бид нарын энэ заалт чинь бол стандарт хангаагүй тохиолдолд 1 хувиар авах тухай асуудал ярьж байгаа байхгүй юу. Тэгвэл үүнийгээ хөнгөлсөн гэсэн юм нь хаана байгаа юм. Байхгүй байна шүү дээ. Тэгэхээр энэ чинь шинээр үүсэх нөхцөл байдал бий болох гээд л байгаа байхгүй юу. Тэгэхээр та хэд энийгээ нэг сайн уншиж үзэж ажлын хэсэг дээрээ үг томъёолол юмнуудаа онохгүй бол яг ингээд гарчих юм бол их сонин юм гарах нь байна шүү. Хэдүүлээ дараа нь 4, 5 жилийн дараа баахан ногоон байгууламжгүй, зогсоолгүй объектууд бариулчихсан тэр нь хуулиар зөвшөөрчихсөн ийм юм болоод буух эзэн, буцах хаяггүй хариуцлага хүлээх хүнгүй болох вий дээ энэ чинь.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний саяын саналыг анхаараарай. Хуулиа бас та нар маань сайн уншиж орж ирээрэй. Энэ чинь саяын таны хэлж байгаа тайлбар дээр ч гэсэн бас алдаатай зүйлүүд байна шүү. Саяын энэ хуулиар чинь 7.1.2-оор ерөөсөө л 2 л орон сууц л чөлөөлөгдөх л хуулийн зохицуулалттай байгаад байгаа байхгүй юу. Тэгээд 3 дахь, 4 дэх, 5 дахь нь угаасаа татварын харилцаанд орчхож байгаа байхгүй юу. Тэгэхээр таны юу гэдэг юм орон сууц хамаарахгүй гэж тайлбарлаж байгаа асуудал чинь бас алдаатай болоод байгаа юм. Тэгэхээр саяын энэ асуудлуудыг анхаарч үзээрэй. Та хэд ажлын хэсгийн түвшинд Төрийн байгуулалтын байнгын хороо дээр.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал

гаргах гишүүн байна уу. Алга байна. Гишүүд сая саналаа хэлсэн. Саяын саналуудыг санал, дүгнэлт дээр протокол дээр онцгойлон тусгаж Төрийн байгуулалтын байнгын хороонд явуулна шүү.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

7.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. 2 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Яг саяын яригдсан асуудлууд хөндөгдөж байгаа шүү. Энэ асуудлыг анхаараарай. Сая Төсвийн тухай хууль дээр яригдсан. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

8.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл. 3 зүйлтэй байгаа.

1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Би нэг зүйл тодруулаад асуугаадахъя.

2 дугаар зүйл дээр заасан бараа, машин механизмын жагсаалт, тоо хэмжээг барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн ангиллын дагуу

Засгийн газар батална гээд заачихсан байгаа юм. Тоо хэмжээг гээд зааж орж ирсэн нь ер нь ямар учиртай юм бэ. Яагаад энийг оруулж ирсэн юм бол. Хуучин бол машин, механизмын жагсаалт гэж байсан санагдаад байгаа юм. Тэгэхээр тоо хэмжээг гэдэг зүйлийг 2 дугаар зүйл дээр нэмж байсан байгаа юм. Энэ дээр тодорхой тайлбар өгөх үү. Сангийн яам 6 номер.

Б.Тэлмүүн: Тэмүүлэн даргын асуултад хариулъя. Энэ Гаалийн албан татвараас чөлөөлөх хуулийг бол бид нар бас нэлээн болгоомжтой байдлаар ажлын хэсэг дээрээ ярьж томъёолсон. Энэ өөрөө орон сууцын барилга, байгууламж шинээр барих НОСК-тай холбоотой харилцаа дээр барилгын материал, машин механизмыг чөлөөлөх асуудал яригдана. Тэгэхээр бид нар барилгын материал, машин механизм тодорхой тоо хэмжээгээр хязгаарлаж яг тухайн дэд төвүүд дээр баригдах төслийнх нь хэмжээгээр хязгаарлахгүй бол бол өөрөө бас тэр ялангуяа машин механизмтай холбоотой олон тооны юу чөлөөлөгдөөд энэ хуулийн зорилго хангагдахгүй байх ийм эрсдэлтэй. Тэгэхээр энэ дээр бол тодорхой тоогоор хязгаарлаж байж, яг энэ төсөлд шаардлагатай тэр төслийн барилгын ажилд шаардлагатай машин механизм, барилгын материалыг чөлөөлье л гэж ийм агуулгаар орсон. Тэгэхээр бид нар хүрээ хязгаарыг нь хумьж байгаа.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Баярлалаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

9.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт

оруулах тухай хуулийн төсөл. 4 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух, санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

10.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. 4 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хууль хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа. Төсвийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Төрийн

*байгуулалтын байнгын хороонд хүргүүлэх
учиртай байгаа.*

*Төрийн байгуулалтын байнгын
хороонд танилцуулах гишүүн нь манай
Байнгын хорооноос гишүүн байгаа юу.
Тогтохсүрэн дарга та танилцуулах уу.
Төрийн байгуулалтын байнгын хороонд
Амартүвшин байгаа юу. Тэгвэл
Тогтохсүрэн дарга Төрийн байгуулалтын
байнгын хороонд танилцуулъя.*

*Хуулийн төслийн анхны
хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. Байнгын
хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал
дууслаа. Хуралдаан хаасныг мэдэгдье.*

*Ажлын хэсэг болоод гишүүдэд
баярлалаа.*

15.29 цаг

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ